



ДУНДГОВЬ АЙМАГ
ДЭЛГЭРЦОГТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 08 сарын 04 өдөр

Дугаар 161

Амардалай

Хязгаарлалтын дэглэмийг цуцлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.11, Засгийн газрын 2018 оны 266 дугаар тогтоол Хорио цээр, хязгаарлалтын дэглэмийн үед хэрэгжүүлэх үйл ажиллагааны журмын 6 дугаар зүйлийн 6.1, Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын 2019 оны А/04 дугаар тушаалын 3 дугаар хавсралт "Бог малын мялзан өвчнөөс урьдчилан сэргийлэх, тэмцэх заавар, Сумын Мал эмнэлгийн тасгийн Мал эмнэлгийн улсын байцаагчийн 2022 оны 08 дугаар сарын 03-ны өдрийн 02 тоот дүгнэлтийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Цахиурт багийн "Өлгий"-н голомтын бүсийн 3 өрхийн малд сүүлчийн өвчилсөн малаас хойш Малын гоц халдварт бог малын мялзан өвчний эмнэл зүйн шинж тэмдэг 33 хоногийн хугацаанд илрээгүй, голомтын болон сэжигтэй бүсийн бог малыг дархлаажуулалтад хамруулаад 21 хоносон тул Сумын Засаг даргын "Хорин цээрийн дэглэмийг хязгаарлалтын дэглэмд шилжүүлэх тухай" А/58 дугаар захирамжийг 2022 оны 08 дугаар сарын 04-ний өдрөөс эхлэн цуцалсугай.

2.Өвчтэй малтай хамт байсан болон өвчлөөд эдгэрсэн малыг 3 сарын хугацаанд өөр сумын нутаг дэвсгэрт шилжилт хөдөлгөөн хийхгүй байх, малчдад малын өвчний талаар анхааруулга сэрэмжлүүлэг өгч, малд тухай бүр клиник үзлэг хийж холбогдох албан газарт мэдээлэл өгч ажиллахыг Дэлгэрбаяндалай, Арвин тэгш баялаг хувийн хэвшлийн мал эмнэлгийн эмч нар, багийн Засаг дарга нарт даалгасугай.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Мал эмнэлгийн тасгийн дарга (Д.Наранцэцэг)-т үүрэг болгосугай.



ЗАСАГ ДАРГЫН ОРЛОГЧ

Л.ЗОЛЖАРГАЛ